**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ**

1995 оны 10 р сарын 03 ны өдөр  No А/132, А/209

Хамтарсан тушаал, захирамжийн заалтад өөрчлөлт оруулах тухай

Мэргэжлийн байгууллага, хүмүүсээс гаргасан саналыг харгалзан ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн засаг даргын 1995 оны А/98 А/138 тоот хамтарсан тушаал, захирамжийн 1-р заалтад "... нөхөн сэргээх эмчилгээний төвийг Гэмтэл согогийн клиникийн эмнэлгийн Түлэнхийн төвтэй нэгтгэн "Түлэнхий-нөхөн сэргээх эмчилгээний төв" болгох ..." гэж орсныг "... нөхөн сэргээх эмчилгээний төвийг Гэмтэл согогийн клиникийн эмнэлэгтэй нэгтгэн Гэмтэл, согог, сэргээн засалтын төв болгон зохион байгуулах ..." гэж өөрчилсүгэй.

2. Одоогийн нөхөн сэргээх эмчилгээний төвийг яаралтай нүүлгэн Гэмтэл согог сэргээн засалтын төвийн дүрмийг баталж, захирлыг томилж ажиллуулахыг Нийслэлийн эрүүл мэндийн газар (н.Буян-Өлзий)-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Нөхөн сэргээх эмчилгээний тусламжийг сайжруулах зарим арга хэмжээний тухай" Эрүүл мэндийн сайдын 1995 оны А/19 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ П.БААСАНЖАВ